ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

---

# Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ГАА-2026/081/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Алтай хот<br>2026 он | Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 99175677 Цахим хаяг:erdenechimegd@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Цэрэнханд<br>Утас: 99086371 Цахим хаяг:Tserenkhand@audit.gov.mn<br>Аудитор: Г.Энхдэлгэр<br>Утас: 99002291 Цахим хаяг: enkhdelgerg@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

Нэг. Хараат бус аудиторын санал, дүгнэлт
Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
Гурав. Аудитын илрүүлэлт
Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийлэл, зөрчлийн нэгтгэл

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.02.24 № 96

танай ________ -ны № ________ -т

АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.БАТСАНЧИР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тус байгууллага нь тайлант онд мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд зургаан арга хэмжээ хэрэгжүүлж, нэг болон гурван жилийн хугацаагаар нийт 18 чиглэлээр элсэлт авч үйл ажиллагаа явуулж байна.

**Аудитын гол асуудал**

Мандалд голомт ХХК-д өгөх 166,477.3 мянган төгрөгийн халаалтын өр төлбөр бүртгэсэн болович төсвийн жилд халаалтын үнэ тариф нэмсэн шалтгаанаар тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

**Бусад асуудал**

Төсвийн захирагчийн Боловсролын ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилт 42 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, 40 арга

822505000266

хэмжээг бүрэн хэрэгжүүлж, 1 арга хэмжээ хэрэгжээгүй, 1 арга хэмжээ дутуу хэрэгжсэнээр 86.3 хувиар дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Г.ГҮНЖИДМАА

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **694,049,680.29** | **838,686,119.80** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 97,371,850.09 | 236,601,102.69 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 97,371,850.09 | 236,601,102.69 |
| **3121** | **Төгрөг** | 97,371,850.09 | 236,601,102.69 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 96,021,850.09 | 236,601,102.69 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 1,350,000.00 | - |
| **33** | **АВЛАГА** | 12,647,574.22 | 13,271,302.93 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 6,959,425.72 | 7,583,154.43 |
| **335** | **Бусад авлага** | 5,688,148.50 | 5,688,148.50 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 5,688,148.50 | 5,688,148.50 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 584,030,255.98 | 588,813,714.18 |
| **351** | **Түүхий эд материал** | 8,546,352.17 | 10,713,802.17 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 7,548,552.17 | 9,917,302.17 |
| 35130 | Эм боох материал | 997,800.00 | 796,500.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 34,182,946.73 | 36,587,938.73 |
| **354** | **Хангамжийн материал** | 541,300,957.08 | 541,511,973.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 12,980,600.80 | 5,975,620.80 |
| 35420 | Аж ахуйн материал | 522,566,023.33 | 527,011,885.83 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 420,369.30 | 2,403.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 5,299,072.00 | 8,487,172.00 |
| 35460 | Хүнсний материал | 34,891.65 | 34,891.65 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,543,066,984.30** | **2,359,451,454.60** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,543,066,984.30 | 2,359,451,454.60 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,870,066,184.30 | 1,685,595,654.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,855,943,399.57 | 2,855,943,399.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,245,134,683.11) | (1,370,225,010.51) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 257,035,968.00 | 212,035,968.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (253,352,634.64) | (210,027,634.60) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 2,064,950,633.92 | 2,077,458,133.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,881,646,527.30) | (1,947,129,193.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 180,301,072.98 | 183,921,072.98 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (139,415,285.12) | (147,765,321.22) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 31,384,240.00 | 31,384,240.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 673,000,800.00 | 673,855,800.00 |
| 39301 | Програм хангамж | 15,655,000.00 | 16,555,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (15,655,000.00) | (15,700,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 673,000,800.00 | 673,000,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,237,116,664.60** | **3,198,137,574.41** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **218,200,027.42** | **225,418,908.66** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 218,200,027.42 | 225,418,908.66 |
| **413** | **Өглөг** | 218,200,027.42 | 225,418,908.66 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 147,971.83 | 8,802,597.15 |
| **4136** | **Бусад өглөг** | 218,052,055.59 | 216,616,311.51 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 217,981,963.59 | 216,377,998.71 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 70,092.00 | 238,312.80 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,018,916,637.18** | **2,972,718,665.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,018,916,637.18 | 2,972,718,665.75 |

| | | | |
|---|---|---|---|
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 784,354,664.10 | 784,354,664.10 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,498,168,855.00 | 1,498,168,855.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (299,523,963.76) | (345,721,935.19) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (228,430,386.36) | (299,523,963.76) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (71,093,577.40) | (46,197,971.43) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,035,917,081.84 | 1,035,917,081.84 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,237,116,664.60** | **3,198,137,574.41** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,387,502,226.50** | **3,918,128,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **161,981,726.50** | **11,404,800.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 161,981,726.50 | 11,404,800.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 24,329,190.00 | 5,524,800.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,329,190.00 | 5,524,800.00 |
| 120009 | Бусад орлого | 21,200,000.00 | - |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 116,452,536.50 | 3,620,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | - | 2,260,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,225,520,500.00** | **3,906,723,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,563,099,900.00 | 3,141,407,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,563,099,900.00 | 3,141,407,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 662,420,600.00 | 765,316,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 662,420,600.00 | 765,316,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,437,492,965.58** | **3,964,326,271.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,437,492,965.58** | **3,964,326,271.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,378,090,740.58 | 3,833,460,261.87 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,862,408,751.40 | 2,208,390,581.70 |
| 210101 | Үндсэн цалин | 1,012,462,715.46 | 1,163,469,356.94 |
| 210102 | Нэмэгдэл | 641,421,856.30 | 746,024,318.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 79,048,399.82 | 72,602,003.12 |
| 210104 | Урамшуулал | 129,475,779.82 | 226,294,903.07 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 232,427,674.03 | 276,317,137.31 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 157,865,974.03 | 190,025,472.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,640,400.00 | 22,037,023.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,320,200.00 | 11,018,469.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,320,200.00 | 11,018,469.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,280,900.00 | 42,217,704.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 749,140,157.73 | 763,627,291.36 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,763,462.05 | 32,755,387.68 |
| 210302 | Түлш, халаалт | 664,974,015.68 | 664,974,015.68 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 63,402,680.00 | 65,897,888.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 103,154,597.41 | 71,699,279.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,014,970.00 | 16,584,680.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,878,873.70 | 4,913,666.30 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 15,623,755.00 | 32,221,820.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 73,636,998.71 | 17,979,113.50 |
| **2105** | **Нормативт зардал** | 87,040,400.00 | 162,859,200.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,295,200.00 | 836,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 85,745,200.00 | 162,022,900.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,018,350.00 | 51,553,174.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 650,000.00 | 4,453,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 61,368,350.00 | 47,100,174.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 281,900,810.01 | 299,013,597.70 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 77,578,124.40 | 66,112,594.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,683,150.00 | 32,257,974.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 189,639,535.61 | 200,643,029.70 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 59,402,225.00 | 130,866,009.56 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,402,225.00 | 129,516,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 55,916,000.00 | 124,566,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,486,225.00 | 4,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,350,000.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,350,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 9.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(49,990,739.08)** | **(46,197,971.43)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 21,102,838.32 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 21,102,838.32 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (21,102,838.32) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(71,093,577.40)** | **(46,197,971.43)** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

(төгрөгөөр)

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,272,579,860.00** | **3,913,317,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **47,059,360.00** | **6,594,300.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 47,059,360.00 | 6,594,300.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 25,859,360.00 | 6,594,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 25,859,360.00 | 6,594,300.00 |
| 120009 | Бусад орлого | 21,200,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,225,520,500.00** | **3,906,723,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,563,099,900.00 | 3,141,407,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,563,099,900.00 | 3,141,407,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 662,420,600.00 | 765,316,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 662,420,600.00 | 765,316,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,131,155,009.91** | **3,760,681,047.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,131,155,009.91** | **3,760,681,047.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,071,752,784.91** | **3,629,815,037.84** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,860,085,670.51 | 2,200,028,880.30 |
| 210101 | Үндсэн цалин | 1,010,139,634.57 | 1,155,107,655.54 |
| 210102 | Нэмэгдэл | 641,421,856.30 | 746,024,318.57 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 79,048,399.82 | 72,602,003.12 |
| 210104 | Урамшуулал | 129,475,779.82 | 226,294,903.07 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 233,005,500.00 | 276,702,802.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 158,443,800.00 | 190,411,137.50 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,640,400.00 | 22,037,023.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,320,200.00 | 11,018,469.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,320,200.00 | 11,018,469.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,280,900.00 | 42,217,704.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 653,202,600.00 | 765,316,090.44 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,639,666.36 | 37,575,857.57 |
| 210302 | Түлш, халаалт | 572,097,423.64 | 664,740,232.87 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 65,465,510.00 | 63,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 83,609,200.00 | 157,525,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 83,609,200.00 | 157,525,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,767,750.00 | 13,096,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,575,750.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 17,974,000.00 | 13,096,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,218,000.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 7,978,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 7,978,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 213,082,064.40 | 209,166,964.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 88,274,865.40 | 85,351,856.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 124,807,199.00 | 123,815,108.60 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **59,402,225.00** | **130,866,009.56** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 59,402,225.00 | 129,516,000.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 55,916,000.00 | 124,566,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,486,225.00 | 4,950,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 1,350,000.00 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,350,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 9.56 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9.56 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **141,424,850.09** | **152,636,752.60** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | **-** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **44,053,000.00** | **13,407,500.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **44,053,000.00** | **13,407,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 44,053,000.00 | 13,407,500.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 44,053,000.00 | 13,407,500.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(44,053,000.00)** | **(13,407,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 97,371,850.09 | 139,229,252.60 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | 97,371,850.09 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 97,371,850.09 | 236,601,102.69 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

( төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,282,523,519.10 | 1,035,917,081.84 | (226,649,306.36) | 3,091,791,294.58 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (1,781,080.00) | (1,781,080.00) |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,282,523,519.10** | **1,035,917,081.84** | **(228,430,386.36)** | 3,090,010,214.58 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (71,093,577.40) | (71,093,577.40) |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,282,523,519.10** | **1,035,917,081.84** | **(299,523,963.76)** | 3,018,916,637.18 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **2,282,523,519.10** | **1,035,917,081.84** | **(299,523,963.76)** | 3,018,916,637.18 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,282,523,519.10** | **1,035,917,081.84** | **(299,523,963.76)** | 3,018,916,637.18 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (46,197,971.43) | (46,197,971.43) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,282,523,519.10** | **1,035,917,081.84** | **(345,721,935.19)** | 2,972,718,665.75 |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,014,665,600.00** | **3,772,738,547.40** | **241,927,052.60** | **94.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **4,014,665,600.00** | **3,772,738,547.40** | **241,927,052.60** | **94.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,860,493,600.00** | **3,643,222,537.84** | **217,271,062.16** | **94.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,246,126,900.00** | **2,200,028,880.30** | **46,098,019.70** | **97.9** |
| 210101 | Үндсэн цалин | 1,316,541,800.00 | 1,155,107,655.54 | 161,434,144.46 | 87.7 |
| 210102 | Нэмэгдэл | 866,264,400.00 | 746,024,318.57 | 120,240,081.43 | 86.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 63,320,700.00 | 72,602,003.12 | (9,281,303.12) | 114.7 |
| 210104 | Урамшуулал | - | 226,294,903.07 | (226,294,903.07) | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **280,765,900.00** | **276,702,802.50** | **4,063,097.50** | **98.6** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 190,920,800.00 | 190,411,137.50 | 509,662.50 | 99.7 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,461,300.00 | 22,037,023.00 | 424,277.00 | 98.1 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 11,230,600.00 | 11,018,469.00 | 212,131.00 | 98.1 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 11,230,600.00 | 11,018,469.00 | 212,131.00 | 98.1 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44,922,600.00 | 42,217,704.00 | 2,704,896.00 | 94.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **772,316,100.00** | **765,316,090.44** | **7,000,009.56** | **99.1** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 42,000,000.00 | 37,575,857.57 | 4,424,142.43 | 89.5 |
| 210302 | Түлш, халаалт | 667,316,100.00 | 664,740,232.87 | 2,575,867.13 | 99.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 63,000,000.00 | 63,000,000.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **224,143,000.00** | **157,525,500.00** | **66,617,500.00** | **70.3** |
| 210502 | Хоол, хүнс | 224,143,000.00 | 157,525,500.00 | 66,617,500.00 | 70.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **17,121,100.00** | **16,595,000.00** | **526,100.00** | **96.9** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,530,100.00 | 3,499,000.00 | 31,100.00 | 99.1 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 13,591,000.00 | 13,096,000.00 | 495,000.00 | 96.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **67,521,100.00** | **7,978,800.00** | **59,542,300.00** | **11.8** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 67,521,100.00 | 7,978,800.00 | 59,542,300.00 | 11.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 252,499,500.00 | 219,075,464.60 | 33,424,035.40 | 86.8 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 118,211,900.00 | 95,260,356.00 | 22,951,544.00 | 80.6 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 134,287,600.00 | 123,815,108.60 | 10,472,491.40 | 92.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **154,172,000.00** | **129,516,009.56** | **24,655,990.44** | **84.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **154,172,000.00** | **129,516,000.00** | **24,656,000.00** | **84.0** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 148,292,000.00 | 124,566,000.00 | 23,726,000.00 | 84.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,880,000.00 | 4,950,000.00 | 930,000.00 | 84.2 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | **-** | **9.56** | **(9.56)** | |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 9.56 | (9.56) | |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **4,014,665,600.00** | **3,913,317,800.00** | **101,347,800.00** | **97.5** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **3,242,349,500.00** | **3,141,407,400.00** | **100,942,100.00** | **96.9** |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,242,349,500.00 | 3,141,407,400.00 | 100,942,100.00 | 96.9 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **772,316,100.00** | **765,316,100.00** | **7,000,000.00** | **99.1** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 772,316,100.00 | 765,316,100.00 | 7,000,000.00 | 99.1 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **-** | **6,594,300.00** | **(6,594,300.00)** | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | | 6,594,300.00 | (6,594,300.00) | |

**2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан**

(төгрөгөөр)

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,350,000.00** |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **1,350,000.00** |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 1,350,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **-** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **1,350,000.00** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **-** |

## Гурав. Аудитын илрүүлэлт

**3.1** Аудитаар 7,899.7 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 1 алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Үндсэн цалин болон унаа хоолны хөнгөлөлтийг 7,899.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь УСНББОУС-1, 2, 15, Санхүүгийн тайлангийн толилуулгын 70-98, 118-125 стандартыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 184,239.7 мянган төгрөгийн зөрчлөөс 17,762.4 мянган төгрөгийн материаллаг зөрчил илэрсэн нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар 184,239.7 мянган төгрөгийн 5 зөрчил илэрснээс 13,268.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 170,971.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн.

### 3.2 Албан шаардлага

1. Орон тооны жишиг нормативт сэтгэл зүйчийн орон тоо батлагдаагүй байхад сургуулийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Б/35 тушаалаар сэтгэл зүйчийг туршилтын хугацаагаар томилж 6,168.1 мянган төгрөгийн цалин, хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.1-т "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 09 дүгээр сарын 14-ний А/185 дугаар “Жишиг бүтэц батлах тухай” тушаалтай нийцэхгүй бөгөөд эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Төсвийн хөрөнгөөр 7,100.0 мянган төгрөгийн үнэтэй 71 ширхэг цамц худалдан авч ажилтан албан хаагчдад тараасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйдийн 8.1-т "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлсэн.

### 3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.3.1 Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

Бараа үйлчилгээний бусад зардал болон сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас 132,343.6 мянган төгрөгийн бараа материал, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

захиалагч шууд худалдан авч болно” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Босго үнээс давсан төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ хуулийн дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж байх.

**3.3.2 Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой**

Мандал голомт ХХК-д халаалтын өглөг бүртгэсэн боловч төсвийн жилд халаалтын үнэ тариф нэмсэн шалтгаанаар тооцоо нийлсэн актаар өр төлбөрийг баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 тоот тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай нийцэхгүй, тохиолдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Халаалтын өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

**3.3.3 Орлогын бүрдүүлэлттэй холбоотой**

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд өөрийн орлого олж байгаа боловч төлөвлөхгүй байгаа нь Т Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 27 дугаар зүйлийн 27.1.7-т "орлого, зарлагыг дотоод гүйлгээнээс бусад нийт гүйлгээний дүнгээр төлөвлөж, бүртгэж, тайлагнах", 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;" гэсэн заалттай нийцэхгүй, тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогыг төлөвлөж, гүйцэтгэлийг хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

*4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургууль | Үндсэн цалин болон унаа хоолны хөнгөлөлтийг 7,899.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | 1 | 7,899.7 | | | 1 | 7,899.7 | 1 | 7,899.7 | - | - | - | - |
| **Дүн** | | **1** | **7,899.7** | | | **1** | **7,899.7** | **1** | **7,899.7** | **-** | **-** | **-** | **-** |

*4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)*

| **Аудитад хамрагдсан байгууллагын нэр** | **Алдаа, зөрчлийн товч утга** | **Нийт алдаа, зөрчлийн дүн** | | **Үүнээс:** | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн** | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймаг дахь Мэргэжлийн боловсролын сургууль | Орон тооны жишиг нормативт сэтгэл зүйчийн орон тоо батлагдаагүй байхад сургуулийн захирлын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн Б/35 тушаалаар сэтгэл зүйчийг туршилтын хугацаагаар томилж 6,168.1 мянган төгрөгийн цалин, хөлс олгосон. | 1 | 6,168.1 | | | 1 | 6,168.1 | | | | |
| | Бараа үйлчилгээний бусад зардал болон сургалт, дадлага, бэлтгэлийн зардлаас 132,343.6 мянган төгрөгийн бараа материал, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэсэн боловч худалдан авах ажиллагаа зарлаагүй. | 1 | - | | | | | 1 | - | | |
| | Мандалд голомт ХХК-д халаалтын өглөг бүртгэсэн боловч төсвийн жилд халаалтын үнэ тариф нэмсэн шалтгаанаар тооцоо нийлсэн актаар өр төлбөрийг баталгаажуулаагүй байна. | 1 | 166,477.3 | | | | | 1 | 166,477.3 | | |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Үндсэн үйл ажиллагааны хүрээнд өөрийн орлого олж байгаа боловч орлогыг төлөвлөөгүй байна. | 1 | 4,494.3 | | | | | 1 | 4,494.3 | | |
| | Төсвийн хөрөнгөөр 7,100.0 мянган төгрөгийн үнэтэй 71 ширхэг цамц худалдан авч ажилтан албан хаагчдад олгосон. | 1 | 7,100.0 | | | 1 | 7,100.0 | | | | |
| **Дүн** | | **5** | **184,239.7** | **-** | **-** | **2** | **13,268.1** | **3** | **170,971.6** | **-** | **-** |